

**Төслийн нэр:** Мэдээлэлзүйн кабинет тохижуулах

**Төсөл хэрэгжүүлэх байгууллага:**Завхан аймгийн Асгат сумын ЕБС

**Төсөл боловсруулсан:** Завхан аймгийн Асгат сумын ерөнхий боловсролын сургуулийн мэдээлэлзүйн багш Ч. Цэрэндолгор, утас 80222720

**Төсөл хэрэгжих газар:** Завхан аймгийн Асгат сум

Манай сургууль нь бага, дунд, ахлах сургуулийн сургалтын үйл ажиллагаа явуулдаг. Бага боловсролд 270 хүүхэд, суурь боловсролд хүүхэд 70, ахлах ангид 60 хүүхэд сурдаг, нийт 23 багш ажилладаг. Манай сургуулийн байр нь 40 хүүхдийн багтаамжтай боловч одоогоор 37 хүүхэд суралцаж байгаа. Эдгээр сурагчдаас сурагч буюу 70% нь Мэдаалэл зүйн хичээл үздэг. Манай мэдээлэл зүйн кабинет нь 8 ширхэг компьютеруудтай.

**Төслийн хэрэгжих хугацаа:** 2024-2025 оны хичээлийн жил

**Төслийн нийт зардал:** 52 000 000 төгрөг

**Төслийг эхлэх хугацаа:** 2024 он

**Холбоо барих хүний нэр:** Завхан аймгийн Асгат сумын сургуулийн захирал Д.Өлзийжаргал утас 95247418, Мэдээлэлзүйн багш Ч.Цэрэндолгор утас 80222720

**Төслийн үндэслэл:** Мэдээллийн эрин зуунд орчин үеийн программыг, боловсролын шинэчлэлтэй уялдуулан суралцагчдын чадамжуудийг тэгш хөгжүүлэх шаардлага зайлшгүй гарч байна.

Тус хичээлийн байрны сургалтын орчин, танхим, тоног төхөөрөмж, үзүүлж таниулах материал орчин үеийн сургалтын үйл ажиллагаа явуулахад хүрэлцээгүй байна. Суралцагчдаас судалгаа авч үзэхэд судалгаанд оролцогчдын 80% нь сургалтын тоног төхөөрөмж техник хэрэгсэл нь хүрэлцээ муу гэсэн санал өгсөн байна.Сургалтын

хөтөлбөртэй яг тохирсон анги танхимыг засаж тохижуулснаар сурагч бүр бие даан тэгш суралцах сургалтын таатай орчин бүрдэж суралцагчдын анхаарал төвлөрөлт нь эрс нэмэгдэж сурах идэвхи оролдлого нь ихэсдэг нь судалгааны үр дүнгээр батлагдсан. Хүүхэд бүрийг тэгш суралцахад мэдээлэлзүйн кабинетийг тохижуулах шаардлагатай байна.

**Төслийн зорилго:**

- Сургууль, багш, эцэг эх, бусад дэмжигч талуудын оролцоог хөгжүүлснээр суралцагч бүрийн мэдлэгийг дээшлүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэх
- Орчин үеийн боловсролын шинэчлэлтэй уялдуулан сурагчдын чадамжуудыг тэгш хөгжүүлэх
- Сурлагын чанарт мэдэгдэхүйц ахиц гаргах

**Төслийн зорилт:**

- Сургалтын таатай орчин бүрдүүлэх
- Суралцагчдын идэвх санаачлалыг дээшлүүлэх
- Мэргэшсэн багш нарыг бэлтгэх
- Ирээдүйдээ итгэлтэй иргэн болгон төлөвшүүлэх
- дотоод нөөц бололцоогоо ашиглан сургалтанд хамруулах

**Төсөлд шаардагдах санхүүгийн хэрэгцээ**

№	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Суурин компьютер acer 17 инч -Processor Intel Dual Core 2.8 Ghz -Chipset Intel G41 -RAM 4 Gb DDR3 -HDD 320 Gb SATA -Video card Intel GMA -Video RAM 1к Mb -Optical drive DVDROM -Sound HD Audio -LAN 10/100 Mbps -Speaker USB speaker -Keyboard USB keyboard mouse -Monitor Acer 19" LSD	12 ш	2482100	29.785.200

2	Сурагч ширээ	10ш	451200	4.512.000
3	Сурагч сандал	15ш	179600	2.694.000
4	Google License	12ш	167600	2.011.200
5	Ухаалаг Самбар MAXHUB  C6530 910мм*1490мм 1x48MPbuilt-in SMART camera, 8array microphones 8m pick up O:5 104000. DDR4 8G/128SSD Core HD Graphics Windows10 enterprise version included Surface.UHD advanced IR terchnology narrow berel design Zero parallax 3mm anti-glare Antibacterial Software.Easinote 5 Speaker:Buid-in 20w*2 -3xUSB3.0 ports 2xUSB2.0 ports , 1x mic, TOUCH2.0x USB type-c x 2, RS232x1 -2xpen -1xwireless keybord mouse	1ш	12665500	12.665.500
6	Багш ширээ	1ш	332100	332.100
	Нийт өртөг			52.000.000